

ҮСХ-ны даргын 2010 оны 09-р сарын 23-ны өдрийн 1/526
тоот тушаалын хавсралтаар батлав.

**Мөнгө, зээл, үнэт цаасны
статистикийн үзүүлэлтийг тооцох
аргачлал**

Улаанбаатар хот
2010 он

АГУУЛГА

I. Нийтлэг үндэслэл	2
II. Ойлголт, тодорхойлолт	2
III. Хамрах хүрээ	5
IV. Ангилал	7
V. Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн үзүүлэлтийг тооцох арга зүй	7
VI. Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр, давтамж	17
VII. Мэдээллийг хэрэглэгчдэд тархаах	18
VIII. Хавсралт 1. Тооцооллын жишээ	20
Хавсралт 2. Мөнгөний үзүүлэлтийн бүтэц	24
Хавсралт 3. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 3.1)	25
Хавсралт 4. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 4.0)	26

МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААСНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

I. Нийтлэг үндэслэл

Энэхүү аргачлалын зорилго нь санхүүгийн салбарын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, мэдээллийг боловсруулагч, хэрэглэгчдэд энэ салбарын статистикийн үзүүлэлт, тэдгээрийн ойлголт, тодорхойлолтыг нэг мөр болгож, нэгдсэн арга зүйгээр хангахад оршино.

Энэхүү аргачлалыг Олон улсын валютын сангаас 2000 онд эрхлэн гаргасан “Мөнгө, санхүүгийн статистикийн гарын авлага”-д тулгуурлан боловсруулав.

II. Ойлголт, тодорхойлолт

Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн үзүүлэлтийг тооцоход ашиглах нэр томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- 2.1 Эдийн засгийн харьяат гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсаас гадаад оронд суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчийн газар, тэдгээрт ажилладаг Монгол улсын иргэд, цэргийн албан хаагч, тэдгээрийн гэр бүлийн гишүүн, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин сууж байгаа Монгол Улсын иргэн; гадаад оронд сурч, эмчлүүлж байгаа Монгол Улсын иргэн, 1 жил хүртэлх хугацаагаар гадаад оронд оршин сууж байгаа Монгол Улсын иргэн, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр 1-ээс дээш жилийн хугацаагаар хууль ёсны дагуу оршин сууж байгаа гадаадын иргэнийг хэлнэ. Харин эдийн засгийн харьяат бус гэж дээрхээс бусад Монгол Улсын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ.
- 2.2 Бэлэн мөнгө гэж Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болон гадаад улсын цаасан мөнгөн тэмдэгт, зоос, бутархай мөнгө, чекийг;
- 2.3 Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө гэж Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгийг;
- 2.4 Харилцах гэж харилцагч тухайн дансны үлдэгдэлдээ багтаан бүх төрлийн төлбөр тооцоо хийхээр банкинд байршуулсан дансыг;
- 2.5 Хадгаламж гэж тухайн данс эзэмшигч хүүний орлого олох зорилгоор хугацаатай эсвэл хугацаа заахгүйгээр хадгаламжийн байгууллагад байршуулсан мөнгөн хадгаламжийг;
- 2.6 Гадаад валютын албан нөөц гэж Монголбанкны эзэмшилд байгаа, захиран зарцуулахад бэлэн, чөлөөтэй хөрвөдөг гадаад валютыг;
- 2.7 Гадаад валют гэж гадаадын мөнгөн тэмдэгт, улс хоорондын худалдаа эдийн засаг, санхүүгийн харилцааны төлбөрт хэрэглэж байгаа гадаад орны мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэж, түүгээр төлөгдөх үнэт цаас, төлбөрийн бусад хэрэгслийг;
- 2.8 Валютын ханш гэж тухайн улсын валютыг өөр нэгэн улсын валютаар илэрхийлсэн дүнг;

- 2.9 Мөнгөжсөн алт гэж олон улсын жишигт хүргэн цэвэршүүлж, гадаад улсын мөнгөний бодлогын чиг үүргийг хэрэгжүүлэгч Төв банкууд, тэдгээртэй ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллага, олон улсын санхүүгийн байгууллагад байршуулсан, гадаад валютаар борлуулахад бэлэн болсон алтыг;
- 2.10 Цэвэршүүлсэн алт гэж алтны агуулгыг нь нэмэгдүүлж цэвэршүүлсэн боловч гадаад валютаар шууд борлуулах нөхцөл хангагдаагүй алтыг;
- 2.11 Үнэт цаас гэж Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг /опцион/, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны зах зээлийн тухай” Монгол улсын хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг;
- 2.12 Өрийн бичиг /бонд/ гэж тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг;
- 2.13 Төв банкны үнэт цаас гэж Монголбанкны мөнгөний бодлогын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжаалж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээрээ эргэн төлөгдөх үнэт цаасыг;
- 2.14 Хувьцаа гэж компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг;
- 2.15 Хэлцэл гэж үнэт цаасыг худалдах захиалгын үнийн саналыг худалдан авах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрснөөр үнэт цаас арилжаалахыг;
- 2.16 Бүртгэлтэй компанийн тоо гэж Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, хувьцааны арилжааг идэвхитэй хийдэг хувьцаат компанийн тоог;
- 2.17 Даатгалын үйл ажиллагаа гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг;
- 2.18 Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа гэж даатгагч, даатгуулагч нар гэрээний дагуу харилцан тохиролцож, даатгуулагч нас барахад, эсхүл тодорхой цаг хугацааны эцэст даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцлөөр хангаж буй хүний амьдралыг даатгах үйл ажиллагааг;
- 2.19 Даатгалын хураамж гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
- 2.20 Даатгалын нөхөн төлбөр гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;

- 2.21 Амь нас, эрүүл мэндийн даатгал гэж иргэдийн эрүүл мэнд, амь нас, ашиг сонирхолд учирч болох хохирол, тохиролцсон болзлыг даатгалын компаниудаар нөхүүлж төлүүлэхээр тохирч хийсэн хэлцлийг;
- 2.22 Эд хөрөнгийн даатгал гэж эд хөрөнгө (материаллаг үнэ бүхий зүйл)-ийг эзэмших, ашиглах, захирахтай холбогдсон даатгалыг;
- 2.23 Хариуцлагын даатгал гэж даатгуулагч нь өөрийн санаатай бус үйл ажиллагаанаас гуравдагч этгээдэд учруулж болох хохирлыг даатгалын компаниар нөхүүлэхээр тохирч хийсэн хэлцлийг;
- 2.24 Санхүүгийн даатгал гэж даатгуулагч нь өөрийн санхүүгийн үйл ажиллагаанд учирч болох хохирол, тохиролцсон болзлыг даатгалын компаниар нөхүүлж төлүүлэхээр тохирч хийсэн хэлцлийг;
- 2.25 Давхар даатгал гэж даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дотоод, гадаадын өөр даатгагчид дахин даатгах хэлбэрийг;
- 2.26 Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд зээлийн үйл ажиллагаа; факторингийн үйлчилгээ; санхүүгийн түрээсийн үйлчилгээ; төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ; төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ; цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ; гадаад валютын арилжаа; итгэлцлийн үйлчилгээ; богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх; хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ зэрэг үйл ажиллагааг багтаана.
- 2.26.1 Зээлийн үйл ажиллагаа гэж банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэж төлөгдөх барьцаа эсхүл батлан даалттайгаар өөрийн болон түүнд хадгалуулсан бусдын мөнгөн хөрөнгийн зохих хэсгийг өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд олгохыг;
- 2.26.2 Факторингийн үйлчилгээ гэж зээлдэгчийн зүгээс зээлдүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах болон шилжүүлэх, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагааг;
- 2.26.3 Санхүүгийн түрээсийн үйлчилгээ гэж түрээслүүлэгч нь түрээслэгчийн захиалсан буюу сонгосон эд хөрөнгийг өөрөө үйлдвэрлэх, эсхүл худалдагч буюу нийлүүлэгчээс өөрийн нэр дээр худалдан авах замаар түрээслэгчид тодорхой нөхцөл, хугацаа, төлбөртэйгээр түрээслэх үйл ажиллагааг;
- 2.26.4 Төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ гэж банкны баталгааны гэрээгээр банк нь үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр тавьсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, үүрэг гүйцэтгэгч нь баталгаа гаргагч банкинд төлбөр төлөх үүргийг тус тус хүлээх үйл ажиллагааг;
- 2.26.5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернет, автомат тоног

төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх үйл ажиллагааг;

- 2.26.6 Гадаад валютын арилжаа гэж гадаад валютыг худалдах, худалдан авах үйл ажиллагааг;
- 2.26.7 Итгэлцлийн үйлчилгээ гэж итгэл хүлээлгэгчийн актив /бэлэн мөнгө, зээл, бусад актив/-ыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг;
- 2.26.8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх гэж тодорхой гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг нэг жил хүртэл хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас болон үүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэх үйл ажиллагааг;
- 2.27 Болзошгүй эрсдэлийн зардал гэж банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны явцад гарсан эрсдэлд зарцуулсан зардал юм. Энэхүү зардалд үнэт цаасны арилжаа, зээл, санхүүгийн түрээс, факторингийн үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгө, авлагын эрсдэлийн зардал тус тус хамаарагдана.
- 2.28 Хадгаламж, зээлийн хоршоо гэж гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх хамтын удирдлага, хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;
- 2.29 Санхүүгийн урсгал ба нөөц гэж санхүүгийн урсгал бүх гүйлгээ, санхүүгийн хөрөнгө/өр төлбөрийн өртгийн өөрчлөлт, хөрөнгө/өр төлбөрийн хэмжээний бусад өөрчлөлт зэргийн аль нэг, эсвэл тэдгээрийн нийлбэрийг;
- 2.30 Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд: Санхүүгийн тусгай хэрэгсэл, үзүүлэлт, бараа бүтээгдэхүүн болон санхүүгийн тусгай эрсдэл (хүүгийн нормын эрсдэл, валютын, ердийн хувьцааны, барааны ханшны эрсдэл, зээл үл төлөхүйн эрсдэл гэх мэт)-тэй холбоотой санхүүгийн хэрэгслийг санхүүгийн зах зээлд арилжиж болно.

III. Хамрах хүрээ

Санхүүгийн салбарт дараахь аж ахуйн нэгж, байгууллага, сан хамрагдана. Үүнд:

- 3.1 Санхүүгийн байгууллага
- 3.1.1 Төв банк /Монголбанк/
 - 3.1.2 Хадгаламжийн байгууллага /Банк, ХЗХ/
 - 3.1.3 Санхүүгийн бусад байгууллага (ББСБ, Даатгалын компани, үнэт цаасны компани)
- 3.2 Санхүүгийн бус байгууллага
- 3.2.1 Төрийн байгууллага
 - 3.2.2 Бусад – хувийн хэвшил
- 3.3 Төрийн удирдлагын байгууллага
- 3.3.1 Засгийн газар

3.3.2 Орон нутгийн засаг захиргааны байгууллага

- 3.4 Өрх /Иргэд/
- 3.5 Бусад байгууллага /Иргэдэд үйлчлэх ашгийн бус байгууллагууд хамрагдана. Тухайлбал: Сан, холбоо, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, төрийн бус байгууллага/
- 3.1 Санхүүгийн секторт эдийн засгийн харьяат санхүүгийн зуучлалын болон санхүүгийн бусад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулна.
- 3.1.1 Төв банк: Монгол улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь Төв банк /Монголбанк/ байна. Төв банк нь мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, Засгийн газрын санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэх, арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах, гадаад валютын нөөцийг эзэмших, зохицуулах үүрэгтэй.
- 3.1.2 Хадгаламжийн байгууллагад Төв банкнаас бусад хадгаламжийн хэлбэрээр хөрөнгө татдаг аж ахуйн нэгж (банк, ХЗХ) хамаарна.
- 3.1.3 Санхүүгийн бусад байгууллага: Монгол Улсын Төв банк болон арилжааны банкнаас бусад, санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага (даатгал, банк бус санхүүгийн байгууллага, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ гэх мэт) багтана.
- 3.2 Санхүүгийн бус секторт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний (санхүүгийн бус) үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулна.
- 3.2.1 Төрийн байгууллагад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрууд (санхүүгийн бус байгууллага) багтана.
- 3.2.2 Бусад байгууллага: Төрийн байгууллагаас бусад санхүүгийн бус байгууллага орно.
- 3.3 Төрийн удирдлагын байгууллагад төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг хамруулна.
- 3.3.1 Засгийн газарт улсын төсвөөс санхүүждэг төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад хуулийн этгээдийг хамруулна.
- 3.3.2 Орон нутгийн засаг захиргааны байгууллагад орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудыг хамруулна.
- 3.4 Өрх (иргэд): Байр, хоол зэрэг зардлууд болон олсон орлогоо бүхлээр нь буюу хэсэгчлэн хувааж амьдардаг бүлэг хүмүүсийг багтаана.
- 3.5 Бусад байгууллага: Иргэдэд үйлчилгээ үзүүлэх зорилготой ашгийн бус байгууллага (сан, холбоо, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, төрийн бус

олон нийтийн байгууллага)-уудыг багтаана. Эдгээр байгууллагууд үнэ төлбөргүй эсвэл маш бага хэмжээний хураамж, төлбөртэйгээр тодорхой бүлэг болон нийгэм, хүнд үйлчилгээ үзүүлдэг.

Санхүүгийн салбарт хамаарах нэгж, байгууллагыг өмчийн хэлбэрээр нь дараахь байдлаар ангилна. Үүнд:

1. Төрийн санхүүгийн аж ахуйн нэгж
2. Хувийн эзэмшлийн санхүүгийн аж ахуйн нэгж
3. Гадаадын эзэмшлийн санхүүгийн аж ахуйн нэгж

IV. Ангилал

4.1. Санхүүгийн салбарын үйл ажиллагааг Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын 4 оронгийн түвшинд ангилна. Үүнд:

4.1.1 Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын код 6511-6720-ийн (ISIC-3.1) хооронд байна.

4.1.2 Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын код 6411-6630-ын (ISIC-4.0) хооронд байна.

Санхүүгийн салбарын ангиллыг хавсралт 3; 4-т харуулав.

V. Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн үзүүлэлтийг тооцох арга зүй

Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн дараахь үзүүлэлтийг тооцож, гаргана. Үүнд:

5.1 Мөнгөний үзүүлэлтийг дараахь байдлаар тооцно.

5.1.1 Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө: Банкнаас гадуурх мөнгө болон банкны касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

ГГБМ = Банкнаас гадуурх мөнгө + Банкны касс дахь бэлэн мөнгө

5.1.2 Нөөц мөнгө /M0/: Хадгаламжийн байгууллагуудын касст байгаа бэлэн мөнгө, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкуудын Монголбанк дахь төгрөг, валютын харилцах, валютын хадгаламжийн нийлбэрээр тооцно.

Нөөц мөнгө /M0/ = Хадгаламжийн байгууллагуудын касст байгаа бэлэн мөнгө + Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө + Банкуудын Монголбанк дахь төгрөг, валютын харилцах, валютын хадгаламж

5.1.3 Бага мөнгө /M1/: Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/ = Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө + төгрөгийн харилцах дансан дахь мөнгө

5.1.3.1 Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө: Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөнөөс

хадгаламжийн байгууллагуудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгийг хасч тооцно.

Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө = Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгө - Хадгаламжийн байгууллагуудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгө

5.1.3.2 Төгрөгийн харилцах дансан дахь мөнгө: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага (улсын болон хувийн байгууллага, иргэд, бусад байгууллага, санхүүгийн бусад байгууллага)-ын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно. Харин хадгаламжийн байгууллага, гадаадын банк, санхүүгийн байгууллага, эдийн засгийн харьяат бус (оршин суугч бус), Засгийн газар (улсын болон орон нутгийн төсөв)-ын төгрөгийн харилцах дансны үлдэгдэл нь мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд орохгүй.

5.1.4 Бараг мөнгө: Төгрөг болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно.

Бараг мөнгө = Төгрөг болон гадаад валютын хадгаламж + Валютын харилцах + цэвэршүүлсэн алтны харилцах + Хадгаламжийн сертификат

5.1.4.1 Төгрөг болон валютын хадгаламж: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага (улсын болон хувийн байгууллага, иргэд, бусад байгууллага, санхүүгийн бусад байгууллага)-ын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно. Хадгаламжийн байгууллага, гадаадын банк, санхүүгийн байгууллага, оршин суугч бус, Засгийн газар (улсын болон орон нутгийн төсөв)-ын төгрөг, валютын хадгаламжийн дансны үлдэгдэл нь бараг мөнгөний тооцоонд орохгүй.

5.1.4.2 Валютын харилцах: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага (улсын болон хувийн байгууллага, иргэд, бусад байгууллага, бусад санхүүгийн байгууллага)-ын валютын харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно. Харин хадгаламжийн байгууллага, гадаадын банк, санхүүгийн байгууллага, оршин суугч бус, Засгийн газар (улсын болон орон нутгийн төсөв)-ын валютын харилцах данс дахь мөнгө бараг мөнгөнд орохгүй.

5.1.4.3 Цэвэршүүлсэн алтны харилцах нь мөнгөний нийлүүлэлтэд орно, харин бусад үнэт металлын харилцах дансны үлдэгдэл орохгүй.

5.1.4.4 Хадгаламжийн сертификат: Хадгаламжийн байгууллагаас гаргасан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж буй хадгаламжийн сертификатыг мөнгөний нийлүүлэлтэд оруулна. Харин бусад байгууллага (бусад хадгаламжийн байгууллага, Засгийн газар)-ын эзэмшиж буй хадгаламжийн сертификатыг оруулахгүй.

- 5.1.5 Мөнгөний нийлүүлэлт /M2/: Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, төгрөг болон валютын хадгаламж, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэр юм.

Мөнгөний нийлүүлэлт /M2/ = Бага мөнгө /M1/ + Бараг мөнгө

- 5.1.6 Мөнгөний үржүүлэгч: Мөнгөний нийлүүлэлт, нөөц мөнгөний харьцаагаар тооцно. Энэ үзүүлэлт нь нөөц мөнгөний нэгж өсөлт нь хэдий хэмжээний нийт мөнгөний өсөлт бий болгосныг харуулна.

$$mm = \frac{M2}{M0}$$

mm - Мөнгөний үржүүлэгч
M2 - Нийт мөнгө
M0 - Нөөц мөнгө

- 5.1.7 Мөнгөний эргэлтийн хурд гэж эдийн засагт нийлүүлэгдсэн мөнгө хэдэн удаа эргэлтэд орж байгааг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд дараахь томъёогоор тооцно. Үүнд:

$$V = \frac{P \cdot Y}{M2} = \frac{ДНБ_{ОНЫХ}}{M2}$$

V - Мөнгөний эргэлтийн хурд
P - Үнэ
Y - Үйлдвэрлэлтийн хэмжээ
ДНБ_{оных} - Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр
M2 - Мөнгөний нийлүүлэлт

- 5.1.8 Долларжилт гэж нэг орны иргэд үндэсний мөнгөн тэмдэгтэйгээ хамт буюу түүний оронд өөр орны валютыг өргөн ашиглаж байгаа үзэгдлийг хэлнэ. Долларжилтийг активын долларжилт (нийт мөнгөнд валютын хадгаламжийн эзлэх хувь), өрийн долларжилт (нийт зээлд валютын зээлийн эзлэх хувь) гэж 2 төрөл болгон авч үздэг. Активын долларжилт нь 20 хувиас бага бол долларжилт бага, 20-70 хувь бол долларжилт дунд зэргийн, 70-аас дээш бол долларжилт өндөр гэж ангилна.

- 5.2 Мөнгөний тойм: Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын үзүүлэлтийн нэгтгэлээс бүрдэнэ. Мөнгөний тоймын актив, пассивын үзүүлэлтийг дараахь байдлаар тооцно. Үүнд:

- 5.2.1 Актив Гадаад цэвэр актив, дотоод цэвэр зээлийн нийлбэрээр тооцно.

- 5.2.1.1 Гадаад цэвэр актив: Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын гадаад активын нийлбэр дүнгээс тэдгээрийн нийт гадаад пассивын нийлбэр дүнг хасч тооцно.

- 5.2.1.2 Дотоод цэвэр авлага: Засгийн газраас авах цэвэр авлага, бусад санхүүгийн байгууллага, улсын салбар, хувийн хэвшил, иргэд, бусад байгууллагаас авах авлагын нийлбэрээр тооцно.

- 5.2.1.2.1 Засгийн газраас авах цэвэр авлага: Төв банк болон хадгаламжийн байгууллагын Засгийн газраас авах авлагын нийлбэр дүнгээс тус байгууллагад байршуулсан Засгийн газрын хадгаламжийн нийлбэр дүнг хасч тооцно. Мөн нийт дүнг улсын болон орон нутгийн төсвөөр ангилж харуулна.
- 5.2.1.2.2 Санхүүгийн бусад байгууллагаас авах авлага: Хадгаламжийн байгууллагаас санхүүгийн бусад байгууллагад олгосон зээлийн дүнгээр тооцно.
- 5.2.1.2.3 Улсын салбараас авах авлага: Хадгаламжийн байгууллагаас улсын байгууллагад олгосон зээлийн дүнгээр тооцно.
- 5.2.1.2.4 Хувийн хэвшлээс авах авлага: Хадгаламжийн байгууллагаас хувийн байгууллагад олгосон зээлийн дүнгээр тооцно.
- 5.2.1.2.5 Иргэдээс авах авлага: Хадгаламжийн байгууллагаас иргэдэд олгосон зээлийн дүнгээр тооцно.
- 5.2.1.2.6 Бусад байгууллагаас авах авлага: Хадгаламжийн байгууллагаас бусад байгууллага (сан, холбоо, үйлдвэрчний эвлэл зэрэг төрийн бус байгууллага)-д олгосон зээлийн дүнгээр тооцно.
- 5.2.2 Пассив: Бага мөнгө /M1/, бараг мөнгө, бусад цэвэр зүйлийн нийлбэрээр тооцно.
- 5.2.2.1 Бусад цэвэр зүйл: Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дээрх актив, пассивын бүлэгт багтаагүй бусад зүйлийг тусгайлан харуулна. Өөрөөр хэлбэл дээр дурьдсан активын зүйлээс бусад активын дүн болон дээр дурьдсан пассиваас бусад пассивын дүнгийн зөрүү болно. Харин Засгийн газрын шугамаар хэрэгжиж буй хөтөлбөрийн гадаад эх үүсвэрээс Монголбанкаар дамжуулан олгогдсон зээлийн эх үүсвэрийн дүнг тусад нь харуулна.
- 5.2.3 Төв банкны мөнгөний тоймын актив, пассивын үзүүлэлтийг дараахь байдлаар тооцно. Үүнд:
- 5.2.3.1 Актив: Гадаад актив, Засгийн газраас авах авлага, банкуудаас авах авлагын нийлбэрээр тооцно.
- 5.2.3.1.1 Гадаад актив: Энэ бүлэгт Төв банкны гадаад активуудыг харуулна. Тодруулбал, касс дахь гадаад валют, гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж, гадаадын Засгийн газрын үнэт цаас, мөнгөжсөн алт, зээлжих тусгай эрх зэрэг олон улсын хэмжээнд гадаад валютын нөөцөд тооцогдох актив

болон тухайн санхүүгийн хэрэгсэлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлагын нийлбэр тооцно.

5.2.3.1.2 Засгийн газраас авах авлага: Засгийн газраас авах авлагыг Төв банкны эзэмшиж буй Засгийн газрын үнэт цаас, Төв банкнаас Засгийн газарт олгосон зээл зэрэг Засгийн газраас авах авлагын нийлбэрээр тооцно.

5.2.3.1.3 Банкуудаас авах авлага: Төв банкнаас банкуудад олгосон бүх төрлийн зээл, санхүүжилт орно.

5.2.3.2 Пассивыг нөөц мөнгө /МО/, Төв банкны үнэт цаас, гадаад пассив, урт хугацаатай гадаад пассив, Засгийн газрын хадгаламж, хөтөлбөрийн зээлийн эх үүсвэр, өөрийн хөрөнгийн сангууд, бусад цэвэр зүйлийн нийлбэрээр тооцно.

5.2.3.2.1 Төв банкны үнэт цаас: Монголбанкнаас гаргасан үнэт цаасны цэвэр дүнг харуулдаг бөгөөд Монголбанкнаас нийт гаргасан үнэт цаасны дүнгээс борлогдоогүй үлдэгдэл, хямдруулалтыг хасч тооцно. Мөн Төв банкны үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн дүн багтана.

5.2.3.2.2 Гадаад пассив: Төв банкны гадаад пассивын үзүүлэлтүүдийг харуулдаг. Гадаад пассивыг Төв банкны гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл, Төв банк дахь гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын харилцах, хадгаламжийн нийлбэрээр тооцно.

5.2.3.2.3 Урт хугацаатай гадаад пассив: Төв банкны 1 жилээс дээш хугацаатай гадаад пассивын дүнгээр тооцно.

5.2.3.2.4 Засгийн газрын хадгаламж: Төв банк дахь Төрийн сангийн нэгдсэн данс, Монгол улсыг хөгжүүлэх сан, нөөцийн сан зэрэг Засгийн газрын дансуудын үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

5.2.3.2.5 Хөтөлбөрийн зээлийн эх үүсвэр: Засгийн газрын шугамаар хэрэгжүүлж буй хөтөлбөрийн дагуу гадаад эх үүсвэрээс олгосон зээлийн эх үүсвэрийн нийлбэрээр тооцно.

5.2.3.2.6 Өөрийн хөрөнгийн сангууд: Төв банкны дүрмийн сан болон бусад сангууд /нөөцийн сан, дахин үнэлгээний сан гэх мэт/, ашиг, алдагдал зэрэг өөрийн хөрөнгийн данснуудын нийлбэрээр тооцно.

5.2.3.2.7 Бусад цэвэр зүйл: Энэ бүлэгт дээрх актив, пассивын бүлэгт багтаагүй бусад зүйлийг цэвэрлэж харуулдаг. Өөрөөр хэлбэл дээр дурьдсан активын зүйлээс бусад активын дүн

болон дээр дурьдсан пассиваас бусад пассивын дүнгийн зөрүүгээр тооцно.

5.2.4 Хадгаламжийн байгууллагын мөнгөний тоймын актив, пассивын үзүүлэлтийг дараахь байдлаар тооцно. Хадгаламжийн байгууллагад Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх арилжааны банкууд, хадгаламж зээлийн хоршоодын үзүүлэлтийг хамруулна.

5.2.4.1 Активыг банкны нөөц, Төв банкны үнэт цаас, гадаад актив, Засгийн газраас авах авлага, санхүүгийн бусад байгууллагаас авах авлага, улсын салбараас авах авлага, хувийн хэвшлээс авах авлага, иргэдээс авах авлага, бусад байгууллагаас авах авлагын нийлбэрээр тооцно.

5.2.4.1.1 Банкны нөөцийг банкуудын касс дахь бэлэн мөнгө, чек болон Төв банк дахь төгрөг, валютын харилцах, хадгаламжийн дансны нийлбэрээр тооцно.

5.2.4.1.2 Төв банкны үнэт цаас: Банкуудын эзэмшиж буй Төв банкны үнэт цаасны цэвэр дүнг харуулж байгаа бөгөөд уг дүнд үнэт цаасны хямдруулалт болон хуримтлуулж тооцсон хүүгийн авлагын дүнгийн нийлбэрээр тооцно.

5.2.4.1.3 Гадаад актив: Банкуудын гадаад активын үзүүлэлтийг харуулна. Гадаад активыг касс дахь гадаад валют, гадаадын банк, санхүүгийн байгууллагад олгосон зээл, тэдгээрт байршуулсан харилцах, хадгаламж, гадаадын үнэт цаас, эдийн засгийн харьяат бус (оршин суугч бус)-д олгосон зээлийн нийлбэрээр тооцно.

5.2.4.1.4 Засгийн газраас авах авлагыг банкуудын эзэмшиж буй Засгийн газрын үнэт цаас, урьдчилан төлсөн татвар зэрэг Засгийн газраас авах авлагын нийлбэрээр тооцно.

5.2.4.1.5 Санхүүгийн бусад байгууллагаас авах авлагыг банкуудаас банк бус санхүүгийн байгууллага болон бусад санхүүгийн байгууллагад олгосон төгрөг болон валютын зээлийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно. Тухайн зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага тусгагдахгүй.

5.2.4.1.6 Улсын салбараас авах авлагыг банкуудаас улсын байгууллагад олгосон төгрөг болон валютын зээлийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно. Тухайн зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага тусгагдахгүй.

5.2.4.1.7 Хувийн хэвшлээс авах авлагыг банкуудаас хувийн хэвшилд олгосон төгрөг болон валютын зээлийн өрийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно. Тухайн

зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага тусгагдахгүй.

- 5.2.4.1.8 Иргэдээс авах авлагыг банкуудаас иргэдэд олгосон төгрөг болон валютын зээлийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно. Тухайн зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага тусгагдахгүй.
- 5.2.4.1.9 Бусад байгууллагаас авах авлагыг дээрхээс бусад төрлийн санхүүгийн бус байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно. Тухайн зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага тусгагдахгүй.
- 5.2.4.2 Пассивыг төгрөгийн харилцах, хадгаламж, гадаад валютын харилцах, гадаад пассив, урт хугацаатай гадаад пассив, Засгийн газрын хадгаламж, Төв банкнаас авсан зээл, өөрийн хөрөнгө, бусад цэвэр зүйлийн нийлбэрээр тооцно.
- 5.2.4.2.1 Төгрөгийн харилцахыг банкууд дахь улсын болон хувийн байгууллага, иргэд, бусад байгууллага, санхүүгийн бусад байгууллагуудын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.
- 5.2.4.2.2 Хадгаламж, гадаад валютын харилцахыг банкууд дахь улсын болон хувийн байгууллага, иргэд, бусад байгууллага, санхүүгийн бусад байгууллагуудын валютын харилцах, төгрөг болон валютын хадгаламжийн дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.
- 5.2.4.2.3 Гадаад пассив: Банкуудын гадаад пассивын үзүүлэлтүүдийг харуулна. Гадаад пассивыг гадаадын банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж, оршин суугч бус (эдийн засгийн харьяат бус)-ын харилцах, хадгаламж, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, гадаад зах зээлээс татсан бусад эх үүсвэрийн нийлбэрээр тооцно.
- 5.2.4.2.4 Урт хугацаатай гадаад пассив: Банкуудын 1 жилээс дээш хугацаатай гадаад пассивын дүнгээр тооцно.
- 5.2.4.2.5 Засгийн газрын хадгаламж: Энэ бүлэгт банкуудад байршиж буй Засгийн газрын дансуудын /төгрөг, валютын харилцах, хадгаламж, тусгай дансууд зэрэг/ үлдэгдлийг харуулах бөгөөд төвлөрсөн болон орон нутгийн төсвөөр ангилж харуулна.
- 5.2.4.2.6 Төв банкнаас авсан зээл: Банкуудын Монголбанкнаас авсан бүх төрлийн зээл, санхүүжилтийн нийлбэрээр тооцно.

5.2.4.2.7 Өөрийн хөрөнгө: Банкуудын дүрмийн сан болон бусад сангууд /нөөцийн сан, дахин үнэлгээний сан гэх мэт/, ашиг/алдагдал, 5 жилээс дээш хугацаатай хугацааны эцэст хувьцаанд хөрвөх нөхцөлтэй хоёрдогч өглөг зэрэг өөрийн хөрөнгийн дансуудын нийлбэрээр тооцно.

5.2.4.2.8 Бусад цэвэр зүйл: Энэ бүлэгт дээрх актив, пассивын бүлэгт багтаагүй бусад зүйлийг тусгайлан харуулна. Өөрөөр хэлбэл дээр дурьдсан активын зүйлээс бусад активын дүн болон дээр дурьдсан пассиваас бусад пассивын дүнгийн зөрүү болно.

5.3 Зээл болон хүүгийн үзүүлэлтийг дараахь байдлаар тооцно. Үүнд:

5.3.1 Зээл: Зээлийн өрийн үлдэгдлийг улсын байгууллага, хувийн хэвшил, иргэд, бусад санхүүгийн бус байгууллага, санхүүгийн бусад байгууллага гэсэн ангиллаар, мөн арилжааны банкаар, нийт дүнгээр нь мэдээлнэ. Иргэд, байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийг зээлийн чанар буюу хугацааны үзүүлэлтээр хэвийн, хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл гэж ангилна.

5.3.1.1 Хэвийн зээл гэж зээл, хүү нь хугацаандаа байгаа зээлийг;

5.3.1.2 Хугацаа хэтэрсэн зээл гэж зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг;

5.3.1.3 Чанаргүй зээл гэж хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хэлнэ.

5.3.1.3.1 Хэвийн бус зээл гэж зээл, хүүгийн хугацаа 91-180 хүртэл хоног хэтэрсэн зээлийг;

5.3.1.3.2 Эргэлзээтэй зээл гэж зээл, хүүгийн хугацаа 181-360 хүртэл хоног хэтэрсэн зээлийг;

5.3.1.3.3 Муу зээл гэж зээл, хүүгийн хугацаа 361-ээс дээш хүртэл хоног хэтэрсэн зээлийг;

5.3.2 Олгосон зээл, төлөгдсөн зээлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилж мэдээлнэ.

5.3.3 Төв банкны үнэт цаасны хүү: Монголбанкнаас тухайн сард гаргасан үнэт цаасны жигнэсэн дундаж хүү юм.

5.3.4 Засгийн газрын үнэт цаасны хүү гэж Засгийн газраас тухайн сард гаргасан үнэт цаасны жигнэсэн дундаж хүү юм.

5.3.5 Банк хоорондын захын хүү: Банк хоорондын зах дээр тухайн сард хийгдсэн нийт арилжааны жигнэсэн дундаж хүү юм. Арилжааны төрлөөр нь банк хооронд олгосон зээлийн, репо нөхцлөөр хийгдсэн арилжааны, Төв банкны үнэт цаасны хоёрдогч захын, овернайт зээлийн, банк хоорондын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү гэж ангилж мэдээлнэ.

5.3.6 Банкуудын зээлийн хүү: Банкуудын тухайн сард олгосон зээлийн жилийн жигнэсэн дундаж хүүг төгрөг, валютаар ангилж харуулна. Мөн банкуудын орлого, зарлагын тайланд үндэслэн тооцсон бодитоор төлөгдсөн хүүг мэдээлнэ.

5.4 Валютын ханшны үзүүлэлтийг дараахь байдлаар тооцно.

5.4.1 Нэрлэсэн үйлчилж буй ханш /NEER/ гэж гадаад худалдааны гол түнш орнуудын валютуудын жигнэсэн дундаж үнэтэй харьцах үндэсний валютын үнийг хэлнэ. Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийг доорхи томъёогоор тооцно.

$$NEER = 100 \prod_{i=1}^n S_{it}^{*w_{it}}$$

S_{it}^* - t хугацааны эцэст нэгж төгрөгтэй харьцах гадаад худалдааны i түншийн валютын ханшны индекс

W_{it} - t хугацааны эцэст нийт худалдаанд i худалдааны түнш орны эзлэх хувийн жин

n - Нийт гадаад худалдааны түнш орны тоо

5.4.2 Бодит үйлчилж буй ханш /REER/ гэж гадаад худалдааны гол түнш орнуудад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний жигнэсэн дундаж үнэтэй харьцах тухайн улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнийн харьцааг илэрхийлнэ. Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийг дараахь томъёогоор тооцно.

$$REER = 100 \prod_{i=1}^n \left[\frac{S_{it}^*}{P_{it}^*} \right]^{w_{it}}$$

P_{it}^* - t хугацаанд i худалдааны түнш орны үнийн индексийг дотоодын үнийн индекст харьцуулсан харьцаа

5.4.3 Тайлант хугацаанд худалдааны түнш орны үнийн индексийг дотоодын үнийн индекст харьцуулсан харьцааг дараахь байдлаар тооцно.

$$P_{it}^* = \frac{P_{it}}{P_t}$$

P_{it}^* - t хугацааны эцэст i худалдааны түнш орны үнийн индексийг дотоодын үнийн индекст харьцуулсан харьцаа

P_{it} - i түнш орны хэрэглээний үнийн индекс, t хугацааны эцэст

P_t - дотоодын хэрэглээний үнийн индекс, t хугацааны эцэст

5.4.4 Нэгж төгрөгтэй харьцах худалдааны түнш орнуудын валютын ханшны индексийг дараахь байдлаар тооцно.

$$S_{it}^* = \frac{S_{it}}{S_{i0}}$$

S_{it}^* - t хугацааны эцэст нэгж төгрөгтэй харьцах гадаад худалдааны i түншийн валютын ханшны индекс

S_{it} - t хугацаанд нэгж төгрөгтэй харьцах i орны дундаж албан ханш

S_{i0} - суурь хугацаанд /1995/ нэгж төгрөгтэй харьцах i орны валютын ханш

5.4.5 Худалдааны түнш аль нэг орны гадаад худалдаанд эзлэх хувийн жинг тухайн улсын экспорт, импортын хувийн жингийн дунджаар тооцно.

$$W_{it} = W_i^x V_x + W_i^m V_m$$

W_{it} - t хугацааны эцэст гадаад худалдааны нийт эргэлтэд i орны эзлэх хувийн жин

X_i - i оронд гаргасан экспортын хэмжээ

M_i - i орноос оруулсан импортын хэмжээ

$$W_i^x = \frac{X_i}{\sum_{i=1}^n X_i} \quad \text{Нийт экспортод i оронд экспортлосон бүтээгдэхүүний эзлэх хувийн жин}$$

$$W_i^m = \frac{M_i}{\sum_{i=1}^n M_i} \quad \text{Нийт импортод i орноос импортлосон бүтээгдэхүүний эзлэх хувийн жин}$$

$$V_x = \frac{\sum_{i=1}^n X_i}{\sum_{i=1}^n X_i + \sum_{i=1}^n M_i} \quad \text{Гадаад худалдааны нийт эргэлтэд экспортын эзлэх хувийн жин}$$

$$V_m = \frac{\sum_{i=1}^n M_i}{\sum_{i=1}^n X_i + \sum_{i=1}^n M_i} \quad \text{Гадаад худалдааны нийт эргэлтэд импортын эзлэх хувийн жин}$$

5.5 Үнэт цаасны үзүүлэлтийг дараахь байдлаар тооцно.

5.5.1 Зах зээлийн үнэлгээ нь Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн нийтэд гаргасан үнэт цаасны тоо тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшны үржвэрээр тодорхойлогдоно.

5.5.2 ТОП -20 индекс: Тухайн индекс тооцох багцад орсон үнэт цааснуудын үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлт бөгөөд Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны өсөлт, бууралт зэргээр үнэт цаасны зах зээлийн ерөнхий чиг хандлагыг энэхүү индексээр тодорхойлно. Индексийг дараахь томъёогоор тооцно.

$$I = \frac{P}{C} \cdot 100$$

I - Тухайн өдрийн индекс
P - Тухайн өдрийн зах зээлийн үнэлгээ
C - Зах зээлийн суурь үнэлгээ

5.6 Даатгалын үзүүлэлтийг дараахь байдлаар тооцно.

5.6.1 Даатгуулагчийн тоо: Даатгуулагч гэдэгт өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулсан иргэн, хуулийн этгээдийг оруулна. Жишээ нь: Нэг байгууллагын 25 ажилтныг гэнэтийн ослын даатгалд даатгуулж байгууллагын эрх бүхий албан тушаалтан даатгалын гэрээг байгуулсан тохиолдолд даатгуулагчийн тоог “25” гэж авна. Мал, амьтан, ургамал даатгуулсан бол даатгуулагчийн тоонд тухайн даатгуулагчийг буюу хуулийн этгээдийг оруулна.

5.6.2 Даатгалын нийт хураамжийн орлогыг даатгалын үйл ажиллагаанаас олсон нийт орлогоор тодорхойлно.

5.6.3 Үйл ажиллагааны нийт зардлыг үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлын нийлбэрээр тооцно.

5.6.4 Даатгалын нөөцийн сангийн өөрчлөлт: Даатгалын нөөцийн сангийн өөрчлөлтийг даатгалын байгууллагуудын оны эхний болон оны эцсийн нөөцийн сангийн зөрүүгээр тодорхойлно. Даатгагч нь гэрээний явцад үүссэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор даатгалын нөөц сан бүрдүүлэх ба даатгалын нөөц сангийн хэмжээ, нөөц санг бүрдүүлэх болон хөрөнгө оруулалтад байршуулах нөхцлийг даатгалын багц дүрмээр тогтооно.

VI. Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр, давтамж

6.1 Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэр нь Төв банкны “Мөнгө, зээлийн статистикийн сарын мэдээ”, Монголын Хөрөнгийн биржийн “Үнэт цаасны зах зээлийн сарын мэдээ”, Санхүүгийн Зохицуулах Хорооны захиргааны мэдээ “Даатгалын байгууллагын үйл ажиллагааны улирлын мэдээ-Д2”, “Даатгалын байгууллагын үйл ажиллагааны жилийн мэдээ-Д1” болон бусад мэдээлэл байна.

6.1.1 Энэхүү аргачлалын 5.1.1 - 5.1.5, 5.2.1 - 5.2.4, 5.3.1, 5.3.3 - 5.3.5 дугаар үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр нь Төв банкны “Мөнгө, зээлийн статистикийн сарын мэдээ” байна. Мөнгө, зээлийн статистикийн мэдээллийг сар бүрийн 7-ны дотор Төв банкнаас Үндэсний статистикийн хороонд ирүүлсэн байна.

- 6.1.2 Энэхүү аргачлалын 5.3.2 дугаар үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр нь “Арилжааны банкны 20.. оны ... улирлын зээлийн тайлан” байна. “Арилжааны банкны 20.. оны ... улирлын зээлийн тайлан”-г 1, 4, 7, 10 дугаар сарын 25-ны дотор Төв банкнаас Үндэсний статистикийн хороонд ирүүлсэн байна.
- 6.1.3 Энэхүү аргачлалын 5.4.1 - 5.4.2 дугаар үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр нь ҮСХ-ны ХҮИ-ийн сарын мэдээ, Гадаад худалдааны Гаалийн мэдээ, Bloomberg байна. Эдгээр үзүүлэлтийг Төв банк тооцож сараар мэдээлнэ.
- 6.1.4 Энэхүү аргачлалын 5.5.1 - 5.5.2 дугаар үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр нь Монголын Хөрөнгийн биржийн “Үнэт цаасны зах зээлийн сарын мэдээ” байна. Үнэт цаасны зах зээлийн мэдээллийг сар бүрийн 4-ний дотор Монголын Хөрөнгийн биржээс Үндэсний статистикийн хороонд ирүүлсэн байна.
- 6.1.5 Энэхүү аргачлалын 5.6.1 - 5.6.3 дугаар үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр нь Санхүүгийн зохицуулах хорооны захиргааны мэдээ “Даатгалын байгууллагын үйл ажиллагааны улирлын мэдээ-Д2”, 5.6.4 дүгээр үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр нь Санхүүгийн зохицуулах хорооны захиргааны мэдээ “Даатгалын байгууллагын үйл ажиллагааны жилийн мэдээ-Д1” мэдээлэл байна. Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлэх “Даатгалын байгууллагын үйл ажиллагааны улирлын мэдээ-Д2” мэдээллээс даатгуулагчийн тоо, хураамжийн орлого, нөхөн олговор гэсэн үзүүлэлтийг амь нас, эрүүл мэндийн, эд хөрөнгийн, хариуцлагын, санхүүгийн хэлбэрээр тус тус ангилж мэдээлнэ.
- 6.1.6 Энэхүү аргачлалын 5.1.1 - 5.1.5, 5.2.1 - 5.2.4, 5.3.1 - 5.3.5, 5.4.1 – 5.4.2, 5.5.1 – 5.5.2 дугаар үзүүлэлтийг сар бүр, 5.6.1 - 5.6.2 дугаар үзүүлэлтийг улирал бүр, 5.6.4 үзүүлэлтийг жилээр тархаана.

VII. Мэдээллийг хэрэглэгчдэд тархаах

- 7.1 Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн мэдээллийг хэвлэмэл эсхүл цахим хэлбэрээр хэрэглэгчдэд тархаана.
- 7.2 Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд дараахь үзүүлэлт болон танилцуулгаар тархаана. Үүнд:
- 7.2.1 Мөнгөний нийлүүлэлт, сарын эцэст;
 - 7.2.2 Банкуудын нэгдсэн тайлан тэнцэл, сарын эцэст;
 - 7.2.3 Гадаад валютын зах зээлийн нэрлэсэн ханш, сарын эцсийн байдлаар;
 - 7.2.4 Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, арилжааны банкуудаар, сарын эцэст;
 - 7.2.5 Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангиллаар, сарын эцэст;

- 7.2.6 Олгосон зээл, төлөгдсөн зээл, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, улирлаар;
 - 7.2.7 Арилжааны банкны хадгаламж, зээлийн хүү, арилжааны банкуудаар, сарын эцэст;
 - 7.2.8 Үнэт цаасны зах зээлийн үзүүлэлт, сарын эцэст;
 - 7.2.9 Даатгуулагчийн тоо, даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, даатгалын төрлөөр;
 - 7.2.10 Зээлийн өрийн үлдэгдэл, бүс, аймаг, нийслэлээр;
 - 7.2.11 Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, бүс, аймаг, нийслэлээр;
 - 7.2.12 Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл, бүс, аймаг, нийслэлээр;
 - 7.2.13 Даатгалын байгууллагын үндсэн үзүүлэлт;
 - 7.2.14 Банк бус санхүүгийн байгууллагын үндсэн үзүүлэлт;
 - 7.2.15 Хадгаламж, зээлийн хоршоодын үндсэн үзүүлэлт;
 - 7.2.16 Мөнгө, зээл, үнэт цаасны ... оны танилцуулга;
- 7.3 7.2.1 - 7.2.7-г сар бүр, 7.2.8-ыг улирал бүр, 7.2.9 - 7.2.15-ыг жилээр тархаана.

VIII. Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн үзүүлэлтийг тооцох жишээ

Энэхүү аргачлалын дагуу үзүүлэлтийн тооцоог жишээгээр үзүүлье.

8.1 Мөнгөний үзүүлэлтийн 2009 оны жилийн эцсийн мэдээллийг цуглуулж, нэгтгэсэн гэж үзье. Уг нэгтгэсэн мэдээллээр дараах үзүүлэлт бидэнд мэдэгдэж байна.

Хүснэгт 8.1 Мөнгөний үзүүлэлт

тэрбум төг

Хугацааны эцэст	Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө	Үүнээс		Төгрөгийн харилцах	Бага мөнгө (M1)	Бараг мөнгө	Үүнээс			Мөнгөний нийлүүлэлт (M2)
		Банкнаас гадуурх мөнгө	Касст байгаа мөнгө				Төгрөгийн хадгаламж	Гадаад валютын хадгаламж	Гадаад валютын харилцах	
2009-12	371.8	285.0	86.8	366.3	651.3	2228.8	1234.3	622.1	372.4	2880.1

- **Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө:** 2009 оны эцсийн банкнаас гадуурх мөнгө 285.0 тэрбум төг, банкны касс дахь бэлэн мөнгө 86.8 тэрбум төгрөгийн нийлбэрээр тооцно.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө = 285.0 тэрбум төг + 86.8 тэрбум төг = 371.8 тэрбум төг

- **Бага мөнгө (M1):** 2009 оны эцсийн банкнаас гадуурх мөнгө 285.0 тэрбум төг, төгрөгийн харилцах 366.3 тэрбум төгрөгийн нийлбэрээр тооцно.

Бага мөнгө (M1) = 285.0 тэрбум төг + 366.3 тэрбум төг = 651.3 тэрбум төг

- **Бараг мөнгө:** 2009 оны эцсийн төгрөгийн хадгаламж 1234.3 тэрбум төг, гадаад валютын хадгаламж 622.1 тэрбум төг, гадаад валютын харилцах 372.4 тэрбум төгрөг /цэвэршүүлсэн алтны харилцах 0, хадгаламжийн сертификат 0/ - ийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгө = 1234.3 тэрбум төг + 622.1 тэрбум төг + 372.4 тэрбум төг = 2228.8 тэрбум төг

- **Мөнгөний нийлүүлэлт (M2):** 2009 оны эцсийн бага мөнгө (M1) 651.3 тэрбум төг, бараг мөнгө 2228.8 тэрбум төгрөгийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт (M2) = 651.3 тэрбум төг + 2228.8 тэрбум төг = 2880.1 тэрбум төг

8.2 Мөнгөний тоймын үзүүлэлтийн тооцоог жишээгээр үзүүлье.

Хүснэгт 8.2.1 Актив

тэрбум төг

Хугацааны эцэст	Нийт актив	Үүнээс	
		Гадаад цэвэр актив	Дотоодын цэвэр зээл
2009-12	3 470.7	1 532.8	1 937.9

- **Мөнгөний тоймын актив:** 2009 оны жилийн эцсийн гадаад цэвэр актив 1532.8 тэрбум төг, дотоод цэвэр зээл 1937.9 тэрбум төгрөгийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний тоймын нийт актив= 1532.8 тэрбум төг +1937.9 тэрбум төг = 3470.7 тэрбум төг

Хүснэгт 8.2.2 Пассив

Хугацааны эцэст	Нийт пассив	Үүнээс			
		Бага мөнгө (M1)	Бараг мөнгө	Хөтөлбөрийн зээлийн эх үүсвэр	Бусад цэвэр зүйл
2009-12	3 470.7	651.2	2 228.8	20.2	570.5

- **Мөнгөний тоймын пассив:** 2009 оны жилийн эцсийн Бага мөнгө (M1) 651.2 тэрбум төг, бараг мөнгө 2228.8 тэрбум төг болон бусад цэвэр зүйл 570.5 тэрбум төгрөгийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний тоймын пассив = 651.2 тэрбум төг + 2228.8 тэрбум төг + 570.5 тэрбум төг = 3470.7 тэрбум төг

8.3 Төв банкны мөнгөний тоймын үзүүлэлтийн тооцоог жишээгээр үзүүлье.

Хүснэгт 8.3.1 Актив

Хугацааны эцэст	Нийт актив	Гадаад актив	Авлага	
			Засгийн газар	Банкууд
2009-12	2 548.8	1 917.6	432.8	198.4

- **Төв банкны мөнгөний тоймын актив:** 2009 оны жилийн эцсийн гадаад актив 1917.6 тэрбум төг, Засгийн газраас авах авлага 432.8 тэрбум төг, банкуудаас авах авлага 198.4 тэрбум төгрөгийн нийлбэрээр тооцно.

Төв банкны мөнгөний тоймын актив=1917.6 тэрбум төг + 432.8 тэрбум төг +198.4 тэрбум төг =2548.8 тэрбум төг

Хүснэгт 8.3.2 Пассив

Хугацааны эцэст	Нийт пассив	Үүнээс							
		Нөөц мөнгө	Төв банкны үнэт цаас	Гадаад пассив	Урт хугацаатай гадаад пассив	Засгийн газрын хадгаламж	Хөтөлбөрийн зээлийн эх үүсвэр	Өөрийн хөрөнгийн сангууд	Бусад цэвэр зүйл
2009-12	2 548.8	733.1	392.5	262.8	116.5	698.1	20.2	222.9	102.6

- **Төв банкны мөнгөний тоймын пассив:** нь нөөц мөнгө 733.1 тэрбум төг, Төв банкны үнэт цаас 392.5 тэрбум төг, гадаад пассив 262.8 тэрбум төг, урт хугацаатай гадаад пассив 116.5 тэрбум төг, Засгийн газрын хадгаламж 698.1 тэрбум төг, хөтөлбөрийн зээлийн эх үүсвэр 20.2 тэрбум төг, өөрийн хөрөнгийн сангууд 222.9 тэрбум төг, бусад цэвэр зүйл 102.6 тэрбум төгрөгийн нийлбэрээр тооцно.

Төв банкны мөнгөний тоймын пассив=733.1 тэрбум төг + 392.5 тэрбум төг +262.8 тэрбум төг +116.5 тэрбум төг+698.1 тэрбум төг+20.2 тэрбум төг+222.9 тэрбум төг+102.6 =2548.8 тэрбум төг

8.4 Хадгаламжийн байгууллагын мөнгөний тоймын үзүүлэлтийн тооцоог жишээгээр үзүүлье.

Хүснэгт 8.4.1 Актив

Хугацааны эцэст	Нийт актив	Банкны нөөц	Төв банкны үнэт цаас	Гадаад актив	Авлага					
					Засгийн газар	Бусад санхүүгийн байгууллага	Улсын салбар	Хувийн салбар	Иргэд	Бусад байгууллага
2009-12	4 089.9	628.4	392.2	405.1	9.2	4.7	20.4	1 716.3	904.9	8.7

- **Хадгаламжийн байгууллагын мөнгөний тоймын актив:** Банкны нөөц 628.4 тэрбум төг, Төв банкны үнэт цаас 392.2 тэрбум төг, гадаад актив 405.1 тэрбум төг, Засгийн газраас авах авлага 9.2 тэрбум төг, санхүүгийн бусад байгууллагаас авах авлага 4.7 тэрбум төг, улсын салбараас авах авлага 20.4 тэрбум төг, хувийн хэвшлээс авах авлага 1716.3 тэрбум төг, иргэдээс авах авлага 904.9 тэрбум төг, бусад байгууллагаас авах авлага 8.7 тэрбум төгрөгийн нийлбэрээр тооцно.

Хадгаламжийн байгууллагын мөнгөний тоймын актив = 628.4 тэрбум төг + 392.2 тэрбум төг + 405.1 тэрбум төг + 9.2 тэрбум төг + 4.7 тэрбум төг + 20.4 тэрбум төг + 1716.3 тэрбум төг + 904.9 тэрбум төг + 8.7 тэрбум төг = 4089.9 тэрбум төг

Хүснэгт 8.4.2 Пассив

Хугацааны эцэст	Нийт пассив	Төгрөгийн харилцах	Хадгаламж, гадаад валютын харилцах /бараг мөнгө/	Гадаад пассив	Урт хугацаатай гадаад пассив	Засгийн газрын хадгаламж	Төв банкнаас авсан зээл	Өөрийн хөрөнгө	Бусад зүйл

- **Хадгаламжийн байгууллагын мөнгөний тоймын пассив:** Төгрөгийн харилцах 366.3 тэрбум төг, бараг мөнгө 2228.8 тэрбум төг, гадаад пассив 385.1 тэрбум төг, урт хугацаатай гадаад пассив 25.5 тэрбум төг, Засгийн газрын хадгаламж 460.9 тэрбум төг, Төв банкнаас авсан зээл 199.2 тэрбум төг, өөрийн хөрөнгө 230.2 тэрбум төг, бусад цэвэр зүйл 193.9 тэрбум төгрөгийн нийлбэрээр тооцно.

Хадгаламжийн байгууллагын мөнгөний тоймын пассив = 366.3 тэрбум төг + 2228.8 тэрбум төг + 385.1 тэрбум төг + 25.5 тэрбум төг + 460.9 тэрбум төг + 199.2 тэрбум төг + 230.2 тэрбум төг + 193.9 тэрбум төг = 4089.9 тэрбум төг

8.5 Зээлийн үзүүлэлтийн тооцоог жишээгээр үзүүлье.

Хүснэгт 8.5 Зээлийн үзүүлэлт


Хугацааны эцэст	Зээлийн өрийн үлдэгдэл	Үүнээс:		
		Хэвийн зээл	Хугацаа хэтэрсэн	Чанаргүй зээл
2009-12	2 655.0	2 071.3	121.7	462.0

- **Зээлийн өрийн үлдэгдэл:** 2009 оны жилийн эцсийн хэвийн зээл 2071.3 тэрбум төг, хугацаа хэтэрсэн зээл 121.1 тэрбум төг болон чанаргүй зээл 462.0 тэрбум төгрөгийн нийлбэрээр тооцно.


Зээлийн өрийн үлдэгдэл= 2071.3 тэрбум төг + 121.7 тэрбум төг + 462.0 тэрбум төг
= 2655.0 тэрбум төг

ЭХ Загвар

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



Зураг 2. Зээлийн өрийн үлдэгдлийн бүтэц



1. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал 3.1

Код	Санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа
	Даатгал, тэтгэврээс бусад санхүүгийн зуучлал
	Мөнгөн гүйлгээ, хадгаламжийн үйл ажиллагаа
6511	Төв банкны үйл ажиллагаа
	Банк хоорондын гадаад тооцоо хийх, банкны үйл ажиллагаанд хяналт тавих, гадаад валютын нөөц бүрдүүлэх, төрийн мөнгөний бодлогыг зохицуулах, гүйлгээнд мөнгө гаргах үйл ажиллагаа орно. (Монгол банк)
6519	Арилжааны банкны үйл ажиллагаа
	Төв банкнаас бусад арилжааны банкнуудын үйл ажиллагаа хамаарна.
	Санхүүгийн бусад үйл ажиллагаа
6591	Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа
	Эд зүйл ашигласны түрээс дэд салбар 71 (машин тоног төхөөрөмж, гэр ахуйн барааны түрээс)-т хамаарна
6592	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа
	Мөнгөн гүйлгээ хийдэг байгууллагаас (банкнаас) гадуур зээлийн үйл ажиллагаа явуулдаг банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа хамаарна.
6593	Бусад баталгаат зээл олгох үйл ажиллагаа
	Үүнд: Хадгаламж, зээлийн хоршоод, сангуудын үйл ажиллагаа хамаарна.
6599	Санхүүгийн бусад гүйлгээ
	Хувьцаа, бонд зэрэг үнэт цаас, үнэт цаасны диллер, санхүүгийн компаний үйл ажиллагаа орно.
	Үүнд Хөрөнгийн биржийн үйл ажиллагаа 6711-т, валют солих үйлчилгээ 6719-т хамаарна.
	Албан журмын нийгмийн даатгалаас бусад
	Даатгал тэтгэврийн сангийн үйл ажиллагаа
6601	Амь даатгал
6602	Тэтгэврийн сан
	Нийгмийн зайлшгүй даатгалын сангийн удирдлага 7530-д хамаарна.
6603	Амь даатгалаас бусад даатгал
	Гал түймэр, эрүүл мэнд, эд хөрөнгийн даатгал орно.
	Санхүүгийн туслах үйл ажиллагаа
	Даатгал, тэтгэврээс бусад санхүүгийн үйл ажиллагаатай нягт холбоотой боловч мөнгөн гүйлгээ хийдэггүй туслах үйл ажиллагаа
6711	Санхүүгийн зах зээлийн удирдлага
	Төрийн хяналт, удирдлагаас бусад зах зээлд зохицуулагч үүрэг гүйцэтгэдэг хөрөнгийн бирж, барааны биржийн ажиллагаа орно.
6712	Үнэт цаасны брокерын үйл ажиллагаа
6719	Санхүүгийн бусад туслах үйл ажиллагаа
	Санхүү, төлбөрийн баримт бичгийн талаар зөвлөгөө өгөх батлах, валют солих үйлчилгээ зэрэг орно.
6720	Даатгал, тэтгэврийн сангийн туслах үйл ажиллагаа
	Даатгалын салбарын мэргэжилтэн, байцаагчдын үйл ажиллагаа орно.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	
	Даатгал, тэтгэврийн сангийн үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээ
	Санхүүгийн зуучлал
6411	Төв банкны үйл ажиллагаа
6419	Мөнгөний зуучлалын бусад үйл ажиллагаа
6420	Холдинг компаний үйл ажиллагаа
6430	Траст, сангууд болон бусад санхүүгийн хэрэгслээр дамжин хийгдэх үйлчилгээ
	Даатгал, тэтгэврийн сангийн үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээ
6491	Санхүүгийн лизингийн үйл ажиллагаа
6492	Зээл олгох бусад үйлчилгээ
6499	Дээрх ангид ороогүй даатгал, тэтгэврээс бусад санхүүгийн үйлчилгээ
	Албан журмын нийгмийн даатгалаас бусад даатгал, давхар даатгал, тэтгэврийн сангийн үйл ажиллагаа
	Даатгалын үйл ажиллагаа
6511	Амь насны даатгалын үйл ажиллагаа
6512	Өмчийн болон бусад даатгалын үйл ажиллагаа
6520	Давхар даатгалын үйл ажиллагаа
6530	Тэтгэврийн сангийн үйл ажиллагаа
	Санхүүгийн бусад үйл ажиллагаа
	Даатгал ба тэтгэврийн сангийн үйл ажиллагаанаас бусад санхүүгийн нэмэлт үйлчилгээ
6611	Санхүүгийн зах зээлийн удирдлагын үйл ажиллагаа
6612	Үнэт цаас ба барааны гэрээний зуучлалын үйл ажиллагаа
6619	Дээрх ангилалд ороогүй санхүүгийн үйлчилгээний туслах үйл ажиллагаа
	Даатгал ба тэтгэврийн сангийн туслах үйл ажиллагаа
6621	Эрсдэл ба хохирлын үнэлгээ өгөх үйл ажиллагаа
6622	Даатгалын агент, брокерын үйл ажиллагаа
6629	Даатгалын төлөөлөгч болон брокеруудын үйл ажиллагаа
6630	Сангийн удирдлагын үйл ажиллагаа

Үндэсний Статистикийн Хороо

-----oOo-----